

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

ТАЙЛАНГИЙН МАЯГТ, ХАВСРАЛТ МЭДЭЭ, НӨХӨХ ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан"-гийн маягт /ТТ-15/-ыг 1 дүгээр, "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн хавсралт мэдээ"-г 2 дугаар, "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягтыг нөхөх заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Тушаалын хавсралтаар батлагдсан тайлангийн маягт, хавсралт мэдээний загварыг Татварын удирдлагын нэгдсэн системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Б.Буяннэмэх/, Мэдээллийн технологийн төв /М.Чойжилсүрэн/-д даалгасугай.
- 3.Батлагдсан маягтын дагуу тайланг хүлээн авч, татварын тооцоо хийхийг Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
- 4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/164, 2020 оны А/24 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.ЗАЯАБАЛ